



ХЯНАЛТЫН АЛБАНЫ 2017 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

2017 оны 04 сарын 03 өдөр

Хяналтын алба нь үйл ажиллагаагаа сар, улирал, жилээр төлөвлөн гүйцэтгэлийг нэгтгэж ажиллаж байна. Төлөвлөгөөт хяналт шалгалтын 2017 оны төлөвлөгөөг 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр гүйцэтгэх захиралаар батлуулан ажиллаж байна.

2017 оны 1 дүгээр улиралд төлөвлөгөөт хяналт шалгалт 6, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 1, гэнэтийн хяналт шалгалт 3, гүйцэтгэлийн хяналт шалгалт 1 –ийг хийсэн байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын тухай

1. 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр хүртэл хугацаанд Захиргаа хүний нөөцийн бодлогын хэлтсийн үйл ажиллагааны журам, ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу явуулж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж хүргүүлэх хяналт шалгалтыг хийж Захиргаа хүний нөөцийн бодлогын хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах, илэрсэн зөрчил ийг арилгах талаар 9 чиглэлийн зөвлөмжийг хүргүүлж 2017.05.15-аас гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхээр илтгэх хуудсаар танилцуулагдаад байна.

2. 2017 оны 01 дүгээр сарын 31-ны өдөр Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээлж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж хүргүүлэх хяналт шалгалтыг хийж компанийн вэб сайтын мэдээллийг шинэчлэн сайжруулахтай холбоотой 19 чиглэлийн зөвлөмжийг 2017.03.01-ний дотор хийж хэрэгжүүлэх талаар чиглэл өгсөн.

Тус шалгалтын үр дүнгийн талаар 2017.03.24-ний өдөр компанийн вэб сайтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд 19 ажлаас 5 ажил огт хийгдээгүй, 3 ажил хэрэгжилт дутуу, 10 ажил бүрэн хэрэгжсэн. 1 ажлын мэдээлэл тавих хугацаа болоогүй байлаа.

3. 2017 оны 01-р сарын 25-нд Шивээ-овоо ХК-ийн ТехБХ-ийн өрөмдлөг тэсэлгээний инженерийн үндсэн чиг үүргийн хүрээнд тэсэлгээний ажлын үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор хяналт шалгалт хийж 3 зөрчлийг арилгах талаар хугацаатай зөвлөмж өгсөн. 2017.05.01-ний өдөр гүйцэтгэлийн хяналт орохоор илтгэх хуудсанд дурдаж танилцуулагдаад байна.

4. 2017 оны 01-р сарын 18-нд Харуул хамгаалалтын өдөр тутмын үйл ажиллагаа гэрээ болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд явагдаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж чиглэл өгөх зорилгоор хяналт шалгалт хийж 4 зөрчил дутагдлыг арилгах талаар хугацаатай зөвлөмж өгсөн. Мөн үйлдвэрлэлийн талбайд тээврийн хэрэгсэл нэвтрэх журмыг шинэчлэх, харуул хамгаалалтын ажлыг сайжруулах шаардлага бий болсныг илтгэх хуудсанд дурдсан.



5. 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Санхүүгийн бүртгэлд тусгагдсан санхүүгийн түрээсийн хөрөнгө болон биет бус хөрөнгийн тооцоог холбогдох хууль болон НБББББ-ийн үндсэн хөрөнгө биет бус хөрөнгийн бүртгэлийн бодлого, горимд заасны дагуу санхүүгийн тайлан, ерөнхий журнал, гүйлгээ балансад үнэн зөв бүртгэсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж хүргүүлэх хяналт шалгалтыг хийж компанийн НБББББ-т заасны дагуу санхүүгийн түрээсийн хөрөнгийг түрээсийн бүртгэлийг үнэн зөв санхүүгийн тайланд бүртгэхтэй холбоотой 2 чиглэлийн зөвлөмжийг 2017.05.31-ний дотор хийж хэрэгжүүлэх талаар чиглэл өгсөн.

6. 2017 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр СЭЗХ-ийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт албан хэрэг хөтлөлт, ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж хүргүүлэх хяналт шалгалтыг хийж Санхүү эдийн засгийн хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгах талаар 6 чиглэлийн зөвлөмжийг хүргүүлж 2017.05.31-ээс гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхээр илтгэх хуудсаар танилцуулагдаад байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тухай:

Шивээ сервис ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд гүйцэтгэх захирлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2017 оны 2 дугаар сарын 6-наас 2017 оны 2 дугаар сарын 24-ны хооронд хийсэн. Тус шалгалтаар Шивээ сервис ХХК-ийн үйл ажиллагааг эрсдэл өндөр гэж дүгнэсэн. Шалгалтын тайланг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зөрчил арилгах тухай 29 зөвлөмжийг 2017.06.30-ны өдрийн дотор хийж хэрэгжүүлэхээр Захирлын зөвлөлөөс үүрэг даалгавар өгсөн.

Гэнэтийн хяналт шалгалтын тухай:

1. 2017.01.05-ны өдөр уулын ИТА-дын цаг ашиглалт, цаг бүртгэлийн байдалд гэнэтийн хяналт шалгалт явуулахад илэрсэн зөрчилгүй сайн байсан.

2. 2017.01.06-ны өдөр компанийн 2016 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө тоолох тооллогын комисс, түүний салбар комиссын үйл ажиллагаанд гэнэтийн хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтаар илэрсэн хэд хэдэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 33-ийн хурлаас дараах шийдвэрийг гаргуулсан. Компанийн 2016 оны жилийн эцсийн тооллогыг үр дүнтэй явуулах, санхүүгийн шинэ програм нэвтрэхтэй холбоотой шинэчлэн сайжруулах ажлын жигд хийх, тооллогын комиссын гишүүдийн цагийн бүртгэл, ирцийн байдалд хяналт тавьж гишүүдийг бүрэн хамруулах, цаг бүртгэлийг албажуулах үүргийг Тооллогын комиссын даргад анхааруулж, хариуцлагатай ажиллах, алдаатай гарсан тушаалыг зөвтгөх талаар ЗХНБХ-т үүрэг өгүүлж зөрчлийг арилгасан.

3. 2017.01.07-ны өдөр хариуцлагатай жижүүрийн ажлын гүйцэтгэлд гэнэтийн хяналт шалгалт хийсэн. Тус шалгалтаар хариуцлагатй жижүүрүүд тухайн өдөр жижүүр хийсэн эсэх, тодорхой ямар шийдвэрүүд гаргасан эсэх талаараа рапортын дэвтэр хөтөлж баталгаажуулдаггүй байсан. 2017 оны 01-р сарын 07 нд №01



дугаартай илтгэх хуудсаар рапортын дэвтэр шинээр хийж рапорт хөтлүүлэх зөвлөмжийг ҮУА-ны диспетчерүүдэд өгсөн.

Бусад ажлын тухай:

Хяналтын алба нь бүрэлдэхүүнээрээ 2017.01.08-2017.01.18 хүртэл 8 хоногийн хугацаанд Монголын дотоод аудитын институтээс явуулдаг Мэргэшсэн дотоод аудит бэлтгэх сургалтанд хамрагдсан.

“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН ХЯНАЛТЫН АЛБА